“Цагаан ямаат кашемир” ХХК-ийн “Ноос, ноолуур боловсруулах үйлдвэр” Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлан 2025

**УЛААНБААТАР ХОТЫН СХД-ИЙН 20-Р ХОРОО,**
**ТОВЧООНЫ ЗАМ 24-Н ТООТ БАЙРЛАХ**
**“ЦАГААН ЯМААТ КАШЕМИР ”ХХК**

# 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТЕРИЙН ДУГААР: 6642616/

# 1. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

## a. Төслийн гол сөрөг нөлөөллийг тодорхойлох

Нөлөөллийн үнэлгээний энэ үе шатанд “Цагаан ямаат кашемир” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Ноолуур боловсруулах үйлдвэр” төслийг хэрэгжүүлснээр байгаль орчны төлөв байдалд гарч болзошгүй нөлөөлөл, түүний хэмжээ, эрчмийг тодорхойлохдоо МУЗГ-ын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”-ыг баримтлан, Магадлан жагсаах (checklist), болон Леопольдын матрицын аргаар тодорхойлов.

Төслийн орон зайн хамрах хүрээ нь шууд болон шууд бус нөлөөллийн бүсээр тодорхойлогдоно. Шууд нөлөөллийн бүс нь 0.73 га талбай бөгөөд энэ талбайн хүрээнд тус үйлдвэрийн үйл ажиллагаа явагдана.

Хүснэгт 2. Гол сөрөг нөлөөлөл ба эх үүсвэр

| № | Нөлөөлөл | Нөлөөллийн эх үүсвэр (үйл ажиллагаа) | Нөлөөллийн шинж чанар |
|---|---|---|---|
| *Агаар орчин* | | | |
| 1 | Тоос, тоосонцор ($PM_{2.5}$, $PM_{10}$) | - Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн<br>- Түүхий эд хүлээн авах үе шат | - Улирлын чанартай.<br>- Тархах хүрээ хязгаарлагдмал.<br>- Салхины хурд бриксийн хурдаас давах, агаарын температур их үед үүснэ.<br>- Ширхгийн хэмжээ, чийгшлийн хэмжээнээс ялгаралт хамаарна. |
| 2 | Хийн хаягдал (Утаа, Угаар, SO, NO, CO) | - Тээврийн хэрэгсэл, машин механизмын хөдөлгүүр | - Агаарыг бохирдуулах боловч хадгалагдах болон тархах хүрээ хязгаарлагдмал. |
| *Усан орчин* | | | |
| 3 | Усны нөөцийн хомсдол | - Технологийн усны хэрэглээ<br>- Унд ахуйн усны хэрэглээ | - Технологийн шийдэл |
| 4 | Хатуу болон шингэн хаягдал | - Ахуйн хог хаягдал<br>- Шатах тослох материалын хаягдал | - Газрын доорх усны бохирдолд өртөгдөх байдал<br>- Удаан сарнина. |
| *Хөрсөн бүрхэвч* | | | |
| 5 | Элэгдэл, эвдрэл | - Зориулалтын бус замаар явснаар хүний хөл хөдөлгөөнд байнга өртөж буй зам, жим дагтарших, талхлагдах<br>- Үйлдвэрийн дотоод зам талбайг зөв зохион байгуулах | - Хөрсний физик, механик шинж чанар өөрчлөлт орох.<br>- Тархалтыг хязгаарлах боломжтой.<br>- Ямар нэг хэмжээгээр нөхөн сэргээх боломжтой. |
| 6 | Бохирдол | - Ахуйн хог хаягдал<br>- Шингэн хаягдал<br>- Шатах тослох материалын асгаралт | - Тархах хүрээ хязгаарлагдмал.<br>- Хөрс бохирдсоноос хөрсний микробиологийн шинж чанар алдагдана.<br>- Хөрсний бохирдол шингээх хурд |
| *Ургамлан бүрхэвч* | | | |
| 7 | Ургамлан нөмрөг | - Эзэмшлийн талбай, барилга байгууламжийн орчим | - Хэмжээ хязгаарлагдмал.<br>- Ургамлын төрөл зүйл устах. |

| | | | |
|---|---|---|---|
| | талхлагдах | | - Ногоон байгууламж, тарималжуулалт хийснээр нөхөн сэргээх боломжтой. |
| *Амьтан* | | | |
| 8 | Дайжих | - Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн<br>- Дуу чимээ | - Тухайн орчинд амьдрах боломжгүй болж дайжих |
| 9 | Хордох | - Хог хаягдал<br>- Шатах тослох материалын асгаралт | - Тархалтын хүрээ хязгаарлагдмал<br>- Хөрсөн дэх бичил биетэн, шавж хорхой үрэгдэх.<br>- Ашиггүй бичил биетэн үржих. |
| *Нийгэм-эдийн засгийн орчин* | | | |
| 10 | Үйл ажиллагаа | - Чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд нийлүүлэх | - Ноос ноолуурын салбарыг боловсруулсан түүхий эдээр хангах |
| 11 | Үндсэн хөрөнгө | - Татварын эх үүсвэр | - Улсын төсөвт хувь нэмэр оруулна. |
| 12 | Шинэ ажиллагсад | - Ажлын байр бий болно. | - Орон нутгийн иргэд орлогын тогтмол эх үүсвэртэй болно. |

## 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛГО

***Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго:***

"Цагаан ямаат кашемир" ХХК-ийн 2024-2028 он хүртэлх 5 жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа МУЗГ-ын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам"-ыг баримталсан бөгөөд төслийн онцлог, байршил зэргээс шалтгаалан БОМТ-нд багтах нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө зэрэг ажлууд хийгдэхгүй болно. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, удирдлага-зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь багтсан болно.

***Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго:***

"Ноолуур боловсруулах үйлдвэр" төслийн үйл ажиллагааг явуулахдаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх, байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд үр дүнтэй байгаа эсэхийг тогтооход оршино. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласнаар доорх зорилтуудыг хангана. Үүнд:

- Байгаль орчны хууль тогтоомжийн холбогдох зүйл заалт, журам заавар, стандартын шаардлагад нийцүүлэн төслийн үйл ажиллагааг явуулна.
- Байгаль орчны менежментийн асуудлаар БОННҮ-ний тайланд боловсруулан тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжүүдийг хэрэгжүүлнэ.
- Ажилчид байгаль орчны хамгаалах асуудалтай холбоотой үүрэг хариуцлагаа ойлгосон байх, сургалтад хамрагдах боломжтой болно.
- Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлийг урьдчилсан тооцоноор байгальд шууд болон шууд бус хэлбэрээр үзүүлэх нөлөөллийг бууруулах, байгаль орчны төлөв байдлыг хадгалж, хамгаална.
- Сум орон нутгийн удирдлага, хяналтын байгууллага, ард иргэдтэй байгаль хамгаалах асуудлаар зөвлөлдөж, тэдний саналыг авч хамтран ажиллах нөхцөл бүрдэнэ.
- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө /БОХТ/ нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал,

хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “Цагаан ямаат кашемир” ХХК-аас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах баримт бичиг юм.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хууль, БОУАӨЯам-наас гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагуудтай уялдуулан боловсруулсан ба тэдгээрийн хэрэгжилтийг 5 жилийн хугацаанд буюу 2024 оноос 2028 оны хугацаанд төлөвлөв. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг холбогдох журам, ерөнхий үнэлгээгээр тавигдсан шаардлагын дагуу урьдчилсан байдлаар тодорхойлж тусгав. Эдгээр зардлууд нь байгаль орчныг хамгаалах ажлын шууд зардлууд бөгөөд түүнтэй холбогдон гарах бусад зураг төслийн буюу туслах чанарын ажлуудын зардал ороогүй.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт хэрэгжиж буй “Цагаан ямаат кашемир” ХХК-ийн “Ноолуур боловсруулах үйлдвэр” төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл бага-дунд эрчимтэй боловч байгалийн хам бүрдэлд үзүүлэх нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх арилгах, бууруулах үүднээс төслийг хэрэгжүүлэхдээ дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Цагаан Ямаат Кашемир ХХКомпани нь 2022 онд -ын Франц улсын 50 хувийн хөрөнгө оруулалтаар үүсгэн байгуулагдсан ба Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20- р хороо Товчооны зам 24 тоот хаягт өөрийн байранд байрладаг.
Тус компани нь ноолууранд анхан шатны боловсруулалт хийх чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд сард 8-10 тонн ноолуур угаах, 5-6 тн самнасан ноолуур боловсруулах хүчин чадалтай.

**Хүний нөөц:**




2022-2025 онд 25-30 үндсэн ажилтан орон тооны төлөвлөлттэйгөөр ажиллаж байсан. Бид хүний нөөцийн бодлогоороо ижил тэгш бололцоог ажилчиддаа олгож, ялгаварлан гадуурхалгүй, хөдөлмөрийн мөлжлөг дарамт шахалтгүй нээлттэй харилцааг бие болгодог бөгөөд үүний нэг батлалгаа нь нийт ажилчдын 60-аас дээш орчим хувийг нь 2-3 жил тогтвор суурьшилтай ажилласан ажилчид эзлэж байна.

**Үйлдвэрлэл:**

Түүхий ноолуурыг компани Баянхонгор аймагийн Баянговь сумнд байрлах Цагаан Ямаат Хоршооноос цагаан ямааний ноолуур бэлтгэн үйлдвэрлүүгээ тээвэрлэн хүлээн авч, ноолуурын  чанараар ангилан ялгаж сэгсрэх буюу хогт хольцоос салган угаах дамжлагад шилжүүлнэ.
Угаасан ноолуурыг дахин сэгсрэн задалж хялгас ялгах дамжлагад оруулан хялгас хогт хольцоос нь салгасан самнасан ноолуур гарган авч баглаж пресслэж экспортоор гаргадаг.
Ноолуур нь угаах 5 машинаар дамжин угаагдах бөгөөд  сард 10-12  тонн угаах хүчин чадалтай хэдий ч түүхий эд бэлтгэл, нөөц зэргээс шалтгаалж угаах хэмжээ сар бүр өөр өөр байдаг.
Нийт 38 ш хялгас ялгах машин, ноолуур сэгсрэх машин 1ш, пресслэгч машин 1ш, угаах машин 5ш, хатаах машин 1ш тоног төхөөрөмжтэй ба суурилагдсан хүчин чадлаараа

ажиллавал жилд 90-110 гаруй тонн самнасан ноолуур гаргах боломжтой ба түүхий эдийн нийлүүлэлтийн хамаарлыг эс тооцвол тасралтгүй 4 улирал үйл ажиллагаатай. Цагаан ямаат кашемир ХХК нь 2024 онд Олон улсын GOTS органик стандартыг хэрэгжүүлж сертификат авсан. Жил бүр баталгаажуулалтын Аудиттад орж. ОРГАНИК БҮТЭЭГДЭХҮҮН үйлдвэрлэлдэг.

**Байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, тайлан 2025**

ЦАГААН ЯМААТ КАШЕМИР ХХК нь 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон тайланг задаргаа биелэлт оруулав.

**Хүснэгт 1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө**

| Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, өртөгч | Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ | Арга хэмжээний хамрах хүрээ | Тоо хэмжээ (5 жилээр) | Нэгж зардал (.төг) | Нийт зардал (.төг) | Хэрэгжүүлэгч | Хамтран хэрэгжүүлэгч | Биелэлтийн шалгуур | Баримтлах хууль журам, стандарт, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ** | | | | | | | | | |
| Хийн хаягдал, Тоосжилт | Орчны агаараас сорьц дээж авч, мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэж, түвшинг тодорхойлуулан, заавар зөвлөмж авч ажиллах | Агаарын чанар | Жилд 4-оос доошгүй удаа | ОХШХ-т тусгагдсан. | | “Цагаан ямаат кашемир” ХХК | Мэргэжлийн байгууллага, судлаач | Шинжилгээний дүн | MNS 4585:2016 |
| | Үйлдвэрийн байрны дотоод орчны агааржуулалтын систем суурилуулах | Ажилчдын эрүүл мэнд | Иж бүрэн | 5,000,000 | | “Цагаан ямаат кашемир” ХХК | Мэргэжлийн байгууллага | Агааржуулалтын систем суурилуулсан байх | - |
| Нийт | | 5,000,000 | | | | | | | |
| **Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ** | | | | | | | | | |
| Зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс | Хаягдал бохир уснаас дээж авч химийн шинжилгээг тогтмол | Төслөөс гарах бохир усанд | Жилд 4 удаа | ОХШХ-т тусгагдсан | | “Цагаан ямаат кашемир” ХХК | Мэргэжлийн байгууллага | Шинжилгээний дүн | “Усны тухай хууль” |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| хэтэрсэн бохирдолтой усаар гадаргын ус бохирдох | хийлгэж байх, мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулан ажиллах | | | | | | | “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”<br>“Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль” |
| Усны нөөц, хэрэглээ | Усыг хэмнэх төхөөрөмжийг үйлчилгээндээ ашиглах /ус хэмнэгч хошуу/ | Ариун цэврийн өрөө, гал тогооны угаалтуурт – 10ш | 70,000 | 700,000 | “Цагаан ямаат кашемир” ХХК | Нийлүүлэгч байгууллага | - | |
| | Усны тоолуурын хэвийн ажиллагааг шалгах, засвар үйлчилгээ хийх | Гүний худаг | 100,000 | | “Цагаан ямаат кашемир” ХХК | Мэргэжлийн байгууллага | - | |
| Ус хэмнэх | Борооны ус хуримтлуулах төхөөрөмж суурилуулах | Төслийн талбайд | 5,000,000 | | “Цагаан ямаат кашемир” ХХК | | - | |
| Нийт | | 5,800,000₮ | | | | | | |
| **Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, газрын гадаргад үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ** | | | | | | | | |
| Тоосжилт, Хөрсний элэгдэл, эвдрэл Дуу чимээ | Төслийн талбайн ногоон байгууламж тарималжуулалтын арчилгаа тордолгоог тогтмол хийх. | 730 $м^2$ талбайд нэмэлтээр 20 ширхэг улиас, 20 ширхэг хайлаас тарих. 2025 оны 4, 9-р сарууд багтаан тарих | 996,000 | | “Цагаан ямаат кашемир” ХХК | Мэргэжлийн байгууллага, ажилчид | Ногоон байгууламж, тарималжуулсан талбай Суулгац тариалсан талбай | “Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай” хууль<br>MNS 5916:2008<br>MNS 5918:2008 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Хөрс болон ургамлан нөмрөг талхлагдах, хөрсөн бүрхэвч бохирдох | Төслийн шаардлагатай талбайг хатуу хучилттай болгох | 1500 $м^2$ талбай | 8,852,500 | “Цагаан ямаат кашемир” ХХК | Мэргэжлийн байгууллага | Төслийн шаардлагатай талбай хатуу хучилттай болсон байх | MNS 5342:2007 |
| Ургамлан нөмрөг талхлагдах, хөрсөн бүрхэвч бохирдох | Төсөл хэрэгжих талбай, хашаанаас гадна хог хаягдал хаяхгүй, газрын гадарга, хөрсийг эвдэхгүй, хөндөхгүй байх арга хэмжээг хэрэгжүүлж байх | Ойр орчмын хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг | Үйл ажиллагааны зардалд тусгагдсан. | “Цагаан ямаат кашемир” ХХК | | | “Хог хаягдлын тухай хууль” |
| Нийт | | 9,848,500₮ | | | | | |
| Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ | | | | | | | |
| Дүйцүүлэн хамгаалал | “Тэрбум мод”үндэсний хөтөлбөрийн хүрээнд нэмж мод тарих. | Төсөл хэрэгжих харьяа дүүрэг, хорооны холбогдох төр захиргааны байгууллагатай хамтран ажиллаж 100 /жил бүр 20/ ширхэг улиас тарих | 480,000 | “Цагаан ямаат кашемир” ХХК | Мэргэжлийн байгууллага, ажилчид | Ногоон байгууламж, тарималжуулсан талбай Суулгац тариалсан талбай | “Тэрбум мод” үндэсний хөдөлөөн |
| Нийт | | 480,000₮ | | | | | |

| Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Амьтан дайжих, үргээх, хордох | Ахуйн гаралтай хог хаягдлын түр цэгийг салхины ноёлох чиглэлийн дор байгуулж, хог хаягдлын ангилан ялгаж, тогтмол хугацаанд зайлуулах, хогийн цэгийг халдваргүйжүүлж байх | Хөрсөн бүрхэвч, амьтны аймаг газрын доорх ус | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардалд тусгав | “Цагаан ямаат кашемир” ХХК | - | - | MNS 5161-1 : 2002 |
| **Нийт** | | | **21,128,500₮** | | | | |

**Хүснэгт:1 <u>Биелэлт тайлан:</u>**

"Цагаан ямаат кашемир" ХХК-ийн "Ноолуур боловсруулах үйлдвэр" төслийн үйлдвэрийн барилга байгууламжууд, ажлын байрны дотоод орчны физик бохирдол болон агаарын чанарын хэмжилт судалгааг 2025.07.29-ны өдөр "Мон Газар Экологи" ХХК-ийн мэргэжилтнүүд хийж гүйцэтгэв.

Үйлдвэрийн дотоод орчны физик бохирдол болон агаарын чанарын хэмжилтийн ажлын хүрээнд төслийн талбайд нийт 8 цэгт 1 удаагийн тус бүр 10 минутын хугацаатай тоос, тоосонцор, дуу шуугиан, нүүрстөрөгчийн дутуу исэл, агаарын чийгшил гэсэн үзүүлэлтүүдийн хэмжилтийг хийв. Хээрийн судалгааны үеэр цаг агаар өдрийн дээд температур 29.7°С, чийгшил 32.8% байв.

Энэхүү ажлын хүрээнд үйлдвэрийн байрны дотоод орчны 6 байршил, гадаад орчны 2 байршилд дуу чимээг C.E.M. DT- 8820 Америк улсад үйлдвэрлэсэн багажаар, тоос, тоосонцор, Нүүрстөрөгчийн дутуу ислийг Temtop M2000 2nd, Temtop air quality 1000 багажаар тус бүр 10 минутын турш Монгол улсын MNS 4585:2025 стандартад заасны дагуу хэмжилт хийсэн болно.






Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, зөвлөгөөний "Мон Газар Экологи" ХХК 2025

- Толгой хамгаалах хэрэгсэл буюу хамгаалалтын малгай
- Гутал
- Бээлий
- Нүдний шил
- Сонсголын эрхтэн хамгаалах хэрэгсэл – чихэвч
- Амьсгалын эрхтэн хамгаалах хэрэгсэл – хошуувч, шүүлтүүртэй баг, маск
- Анхны тусламжийн эмийн сан

**Агаарын чанарын хэмжилтийн үр дүн:**

Агаарын чанарын хяналт шинжилгээний дүнгээр төслийн талбайн гадаад орчны PM2.5 нь 2.8-3.6 мкг/м$^3$, PM10 нь 4.7-6.1 мкг/м$^3$ буюу тоосонцрын хэмжилт стандарт утгаас хэтрээгүй үзүүлэлттэй байгаа бол үйлдвэрийн дотоод орчин дахь самнах, сүлжих үйлдвэрийн PM2.5 нь 289.0 мкг/м$^3$, PM 10 нь 418.1 мкг/м$^3$ буюу стандарт утгаас хэтэрсэн үзүүлэлттэй буюу үйлдвэрийн тоног төхөөрөмж ажиллаж буй зааланд маш их бохирдолтой байгаа боловч өмнө 2024 онд хийсэн хэмжилтийн үр дүнгээс бохирдлын хэмжээ багассан үзүүлэлт харагдаж байна, харин үйлдвэрийн оффис болон агуулахад хийсэн тоосонцрын хэмжилтийн дүн агаарын чанарын стандарт утгаас хэтрээгүй байна. Төслийн талбайн гадаад орчны дуу чимээ 50.1-54.4 дБ буюу хэмжилтийн үр дүнд стандартаас давсан утга илрээгүй байна. Мөн үйлдвэрийн дотоод орчны дуу чимээний хэмжилтийн үр дүнгээр үйлдвэр дотор 62.4 дБ, самнах сүлжих үйлдвэр дотор 76.8 дБ буюу стандарт утгаас 2.4-16.8 дБ-аар илүү буюу стандарт утгаас давсан үзүүлэл байхгүй байна.

Дээрх үр дүн нь үйлдвэрийн байранд шинэ агааржуулалтын иж бүрэн систем суурилуулсантай холбоотойгоор 2024 оны агаарын чанарын хэмжилтийн үр дүнгээс эрс сайжирсан байгаа нь хэмжилтийн үр дүнгээр тогтоогдлоо. Үйлдвэрийн дотоод болон орчны дуу чимээний хэмжилтийн үр дүн 6 байршилд стандарт утгаас хэтрээгүй байна.

БОЛОВСРУУЛСАН: "МОН ГАЗАР ЭКОЛОГИ" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.БОЛДБАЯР

8 "Цагаан ямаат кашемир" ХХК-ийн "Ноолуур боловсруулах үйлдвэр" төслийн дотоод орчны физик бохирдол, агаарын чанарын хэмжилтийн үр дүнгийн тайлан

**Биелэлт тайлан:**

Үйлдвэрийн самнах цех болон угаах цехэд ажлын байрны нөхцлийг сайжруулаж дотоод орчны агааржуулалтын систем болон сорох систем суурилуулсан.



“ТОП СТИЙЛ ВЕНТ” ХХК

“Цагаан Ямаат Кашимер” ХХК 1,2-р агуулах, ялгааны өрөө, химийн агуулахын САЛХИВЧНЫ СИСТЕМИЙН ФОТО АКТ

Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг 12-р хороо 1-56
Имэйл хаяг: svt.263250@gmail.com
Утас: 95854433, 98111011, 98111710



“ТОП СТИЙЛ ВЕНТ” ХХК

Гүйцэтгэлийн акт: “ЦАГААН ЯМААТ КАШИМЕР” ХХК ноолуурын үйлдвэр 2025-06-19

“ТОП СТИЙЛ ВЕНТ” ХХК-ний инженер техникийн ажилчид **Захиалагч: “Цагаан Ямаат Кашимер” ХХК-ны гаргасан хүсэлтийн дагуу тус байгууллагын үйлдвэрийн самнах болон угаах цехэд нэмэлтээр агааржуулалтын системийн хийц хоолой угсралт. тоног төхөөрөмж угсрах** ажлыг, барилгын норм дүрмийн дагуу, тус байгууллагатай хийсэн гэрээний дагуу хийж гүйцэтгэлээ.

Үүнд: Агаар оруулах -2, Агаар сорох-1, нийт 3 систем багтана.

- Сорох болон өгөх ерөнхий шугам хоолой 700x300/600x300/500x300/400x300 хөндлөн огтлолын талбайтай, бохир агаар хаях хоолойг үйлдвэрийн зүүн талын ханаар гарган доош буулган угсрав. Агаар өгөх амсар үйлдвэрийн хойд талын ханаар гарган агаар авах амсарыг хананд суурилуулж ус орохоос сэргийлж силикон тойруулж хийж өгөв. Хэвтээ шугамыг 2,5-3м тутам бэхлэв
- Угаах цехийн агаар оруулах дутуй шугам бөгөөд бүгдийг дулаалж угсрав. Хоолойн хөндлөн огтлол ф400/ф300/ф250/ф200/ф150. Агаар өгөх вентилятор ВЦ-1446 7,5квт 1450эрг/мин бүтээмж-13000мкуб/цаг гаднаа нэмэлт венткамер мөн хийж өгсөн.
- Ерөнхий сорох болон агаар өгөх системийн сэнсий бүтээмж 6000мкуб/цаг, хэмжээ 700x400
- Агаар дамжуулах шугам хоолойг бэхлэхдээ норм дүрмийг баримтлан ф8-резба болон квадрат квадрат-40/20 төмрөөр бүслүүр хийж тогтоов.
- Сорох системийн салаа шугам 400x180 ханаа дагуулж доош буулган сорох амсарыг суурилуулав.Агаар өгөх системийн салаа шугам 300x300 доош отводоор эргүүлж ф250/ф140 чиглүүлэгчтэй агаар өгөх амсар суурилуув.
- Дээрхи ажлуудыг харуул хамгаалалт, арын алба инженер техникийн албатай харилцан тохиролцож газар дээр нь ярилцаны үр дүнд амжилттай хийж гүйцэтгэв.
- Гүйцэтгэсэн ажлыг сайн дүнтэй хийгдсэн гэж талууд дүгнэв. Нэмэлт мэдээллийг фото актнаас сайн харна уу. Фото акт хавсаралтаар

**Ажил хүлээлцсэн:**

**Захиалагч:**

**“Цагаан Ямаат Кашимер” төлөөлж:**
Гүйцэтгэх захирал

М.Мөнхөлзий

**Гүйцэтгэгчийг төлөөлж**

**“Топ Стийл вент” ХХК-г**

ХАС-н инженер З.Гантулга



“ТОП СТИЙЛ ВЕНТ” ХХК Магадлах фото зураг “ЦАГААН ЯМААТ КАШИМЕР” ХХК самнах цех

| | | Зургийн тайлбар |
|---|---|---|
| | 2025 06 сар | 2 давхрын техникийн өрөөний системийг тусад нь угсарч жижиг hood амсар гадна хананд суурилуулсан байдал |
| | 2025 06 сар | Самнах цехийн хойд талын жигүүрийн агаар сорох болон өгөх системийн ерөнхий шугамыг салаатай нь угсарсан байдал |

ГҮЙЦЭТГЭГЧ: “ТОП СТИЙЛ ВЕНТ” ХХК ГҮЙЦЭТГЭСЭН ГАЗАР: 22 ТОВЧОО

**<u>Биелэлт тайлан:</u>**

Хаягдал бохир уснаас дээж авч химийн шинжилгээг тогтмол хийлгэж мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулан ажилласан.



KhanLab

ХАНЛАБ ХХК
Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 17 р хороо, Богд Жавзандамба гудамж 34/6 тоот, Хан Рашаан компанийн байр
Утас: 70109968, 99995316
http://www.khanlab.mn

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

ЗАХИАЛАГЧИЙН НЭР: **ЦАГААН ЯМААТ ХХК** ДЭЭЖИЙН ТӨРӨЛ, ТОО **Саарал ус, 1**

ЗАХИАЛГА №: **2025/302**

ХҮЛЭЭН АВСАН ОГНОО: **2025.03.13**
ШИНЖИЛСЭН ОГНОО: **2025.03.27**

ДЭЭЖ БОЛОВСРУУЛАЛТ: **хийгдээгүй**

ХУУДАСНЫ ТОО: 1

Сорилтын үр дүн зөвхөн тухайн дээжинд хамаарна.
Дээжлэлтийн талаарх асуудлыг манай лаборатори хариуцахгүй болно.

Чанарын менежер Д. Пүрэвжаргал

*Хамтран ажилласан танд талархлаа.*



**ЗАХИАЛГА №: 2025/302**
**ДЭЭЖИЙН ДУГААР: Саарал ус**
**ЛАБОРАТОРИЙН ДУГААР: Л-1841**

| № | ЭЛЕМЕНТ | НЭГЖ | ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН | ЗӨВШӨӨРӨГДӨХ ХЭМЖЭЭ /MNS 4943:2015/ | СТАНДАРТ АРГА |
|---|---|---|---|---|---|
| 1 | pH | - | 7.39 | 6-9 | MNS ISO 10523:2001 |
| 2 | Үлдэгдэл хлор, $Cl_{үлд}$ | мг/л | <0.10 | 1.0 | |
| 3 | Хуурай үлдэгдэл, TDS | мг/л | 36.00 | 1000 | MNS 4423:1997 |
| 4 | Умбуур бодис, TSS | мг/л | <3.0 | 30 | |
| 5 | Исэлдэх чадвар /$KMnO_4$/ | мг$O_2$/л | 5.84 | 20 | |
| 6 | Химийн хэрэгцээт хүчилтөрөгч, COD | мг$O_2$/л | <20.0 | 50 | MNS ISO 6060:2001 |
| 7 | Биологийн хэрэгцээт хүчилтөрөгч, BOD | мг$O_2$/л | <3.0 | 20 | MNS ISO 5815:2001 |
| 8 | Хүхэртустөрөгч, $H_2S$ | мг/л | <0.10 | 0.5 | MNS 5597:2006 |
| 9 | Хром, Cr (VI) | мг/л | <0.05 | 0.01 | MNS ISO 11083:2001 |
| 10 | Хөнгөнцагаан, Al | мг/л | <0.025 | 0.5 | |
| 11 | Мышьяк, As | мг/л | <0.01 | 0.01 | |
| 12 | Бор, B | мг/л | 0.04 | 0.50 | |
| 13 | Бари, Ba | мг/л | 0.02 | 1.5 | |
| 14 | Берилли, Be | мг/л | <0.001 | 0.001 | |
| 15 | Кобальт, Co | мг/л | <0.001 | 0.02 | |
| 16 | Кадми, Cd | мг/л | <0.005 | 0.03 | |
| 17 | Хром, Cr | мг/л | <0.005 | 0.3 | |
| 18 | Зэс, Cu | мг/л | <0.02 | 1.0 | |
| 19 | Төмөр, Fe | мг/л | 0.10 | 1.0 | |
| 20 | Марганец, Mn | мг/л | 0.02 | 0.5 | MNS (ISO) 11885:2011 |
| 21 | Молибден, Mo | мг/л | <0.005 | 0.5 | |
| 22 | Никель, Ni | мг/л | <0.005 | 0.2 | |
| 23 | Фосфор, P | мг/л | 14.97 | 1.5 | |
| 24 | Хартугалга, Pb | мг/л | <0.01 | 0.1 | |
| 25 | Сурьма, Sb | мг/л | <0.01 | 0.05 | |
| 26 | Селен, Se | мг/л | <0.01 | 0.02 | |
| 27 | Стронци, Sr | мг/л | 0.28 | 2.0 | |
| 28 | Ванади, V | мг/л | <0.01 | 0.10 | |
| 29 | Уран, U | мг/л | <0.03 | 0.05 | |
| 30 | Цайр, Zn | мг/л | 0.03 | 3.0 | |
| 31 | Цианид, $CN_{нийт}$ | мг/л | <0.002 | 0.050 | MNS ISO 6703(I):2006 |
| 32 | Цианид, $CN_{чөл}$ | мг/л | <0.002 | 0.050 | MNS ISO 6703(II):2006 |
| 33 | Мөнгөн ус, Hg | мг/л | <0.001 | 0.005 | MNS 4420:1997 |

Хуудас 1-1



KhanLab

ХАНЛАБ ХХК
Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 17 р хороо, Богд Жавзандамба гудамж 34/6 тоот, Хан Рашаан компанийн байр
Утас: 70109968, 99995316
http://www.khanlab.mn

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

ЗАХИАЛАГЧИЙН НЭР: **ЦАГААН ЯМААТ ХХК** ДЭЭЖИЙН ТӨРӨЛ, ТОО **Саарал ус, 1**

ЗАХИАЛГА №: **2025/1146**

ХҮЛЭЭН АВСАН ОГНОО: **2025.08.11**
ШИНЖИЛСЭН ОГНОО: **2025.09.08**

ДЭЭЖ БОЛОВСРУУЛАЛТ: **хийгдээгүй**

ХУУДАСНЫ ТОО: 1

Сорилтын үр дүн зөвхөн тухайн дээжинд хамаарна.
Дээжлэлтийн талаарх асуудлыг манай лаборатори хариуцахгүй болно.

Чанарын менежер Д. Пүрэвжаргал

*Хамтран ажилласан танд талархлаа.*

**Биелэлт тайлан:**

Усны нөөц, хэрэглээ Усыг хэмнэх төхөөрөмжийг үйлчилгээнд ашиглах байгаа /ус хэмнэгч хошуу/





Усны тоолуурын хэвийн ажиллагааг шалгах, засвар үйлчилгээ хийх



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

УСНЫ ТООЛУУРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ

№ ЭУ 125706

Цагаан ямаат кашмер -д
(хэрэглэгчийн нэр)
ашиглаж байгаа LXLGR 50 загварын 15 м³/ц хэмжих хязгаартай, 50 мм-ийн голчтой № 2110113973 -ын халуун, хүйтэн усны тоолуурыг № 017 лацаар битүүмжилж
(доогуур зурах)
2026 оны 01 -р сарын 26 -ны өдөр хүртэл улсын баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: 001154 м³

Лабораторийн тэмдэг

Улсын шалгагчийн гарын үсэг, тэмдэг

2024 оны 01 -р сарын 26 -ны өдөр

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

УСНЫ ТООЛУУРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ

№ ЭУ 204442

Цагаан ямаат кашмер. -д
(хэрэглэгчийн нэр)
ашиглаж байгаа LXSG загварын 10 м³/ц хэмжих хязгаартай, 40 мм-ийн голчтой № 2204002999 -ын халуун, хүйтэн усны тоолуурыг № 014 лацаар битүүмжилж
(доогуур зурах)
2026 оны 12 -р сарын 19 -ны өдөр хүртэл улсын баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: 01606 м³

Лабораторийн тэмдэг

Улсын шалгагчийн гарын үсэг, тэмдэг

2024 оны 12 -р сарын 19 -ны өдөр

**<u>Биелэлт тайлан:</u>** Борооны ус хуримтлуулах төхөөрөмж суурилуулсан.



БАТЛАВ: "Цагаан Ямаат Кашемир " ХХК –ий Гүйцэтгэх Захирал М.Мөнх-Өлзий

БАТЛАВ: "Каанж Эрдэнэ " ХХК -ий ЗАХИРАЛ Т.Ням-Эрдэнэ

БАРИЛГЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2025 оны 03 –р сарын 31 өдөр № 25/02-А Улаанбаатар хот

Энэхүү "ажил гүйцэтгэх гэрээ" /цаашид гэрээ гэх/-г нэг талаас **"Цагаан Ямаат Кашемир"** ХХК, 6642616 регистерийн дугаартай /цаашид захиалагч гэх/ төлөөлж Гүйцэтгэх захирал М.Мөнх-Өлзий, нөгөө талаас "**Каанж Эрдэнэ"** ХХК , 6943748 регистерийн дугаартай, /цаашид гүйцэтгэгч гэх/ төлөөлж Гүйцэтгэх захирал Т.Ням-Эрдэнэ нар Монгол улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, БНбД-ийг удирдлага болгон дараах нөхцлийг харилцан тохиролцож гэрээ байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү гэрээгээр ажил Гүйцэтгэгч нь Захиалагчаас өгсөн зураг төслийн дагуу ажлыг гүйцэтгэх, ажлын үр дүнг хүлээлгэн өгөх, Захиалагч нь уг ажлын үр дүнг хүлээн авах, хөлс төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2 Гүйцэтгэгч нь захиалгын дагуу дараах ажлуудыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж Захиалагчид шилжүүлнэ. Үүнд:

1.2.1 Гүйцэтгэгч нь Сонгино Хайрхан дүүрэг, 20-р хороо, **Цагаан Ямаат Кашемир ХХК**-ийн үйлдвэрийн сэндвичин барилгын засварын ажлын хийх.

1.3 Захиалагч нь гүйцэтгэсэн ажлыг хүлээн авч гэрээгээр тохирсон хэлбэр, хугацаанд төлбөрийг төлнө.

1.4 Гэрээнд заасан ажил үүргээс бусад ажил гүйцэтгэхээр бол гэрээний нэмэлтээр тусгах бөгөөд бичгэн хэлбэрээр баталгаажуулна.

2. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА

2.1 Гүйцэтгэгч нь гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны 04 сарын 20нд Захиалагчид хүлээлгэн өгнө.

2.2 Энэхүү гэрээ гүйцэтгэгч тал ажлаа бүрэн гүйцэтгэж захиалагч талд хүлээлгэн өгч, эцсийн тооцоо хийх, чанарын баталгаат хугацаа дуусах хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

3. ГЭРЭЭНИЙ ҮНЭ БА ТӨЛБӨР ТООЦОО ХИЙХ ХЭЛБЭР

3.1 Ажлын хөлсийг дараах байдлаар тохиров.

3.1.1 Гэрээт ажлын хөлс **51 075 750** /Тавин нэгэн сая далан таван мянга долоон зуун тавин төгрөг /

| № | Үйлдвэрийн барилгын засварын ажил | Нийт дүн |
|---|---|---|
| 1 | Дээврийн засвар | 3,800,000 |
| 2 | Усны хаялга | 3,000,000 |
| 3 | Агуулахын хаявч | 5,500,000 |
| 4 | Агуулахын дотор хана засвар | 6,500,000 |
| 5 | Үйлдвэрийн ханын сийгэлт | 3,800,000 |
| 6 | Аваарын шат | 2,500,000 |
| 7 | Бараа материаль | 21,332,500 |
| | **НИЙТ ДҮН** | 46,432,500 |
| | **НӨАТ** | 4,643,250 |
| | **Нийт дүн** | **51,075,750** |

байна.

3.2 Гэрээт ажил гүйцэтгэх үнэнд НӨАТ багтсан бөгөөд, ажлын хөлс, Хөдөлмөр хамгаалалын зардал болон бусад зардал багтсан болно.

3.3 Гэрээт ажлын хөлсийг дараах графикын дагуу туслан гүйцэтгэгч компанид олгоно. Үүнд:

3.3.1 Урдчилгаа төлбөр 70 хувь буюу 35,000,000 /Гучин таван сая/ төгрөгийг гэрээ баталгаажуулсанаар олгоно.Үлдэгдэл 30 хувь ажлыг дуусгавар болгож захиалагч тал баталгаажуулан хүлээн авснаар төлнө.

1




**<u>Биелэлт тайлан:</u>** Төслийн талбайн ногоон байгууламж тарималжуулалтын арчилгаа тордолгоог тогтмол хийх.







- Төслийн шаардлагатай талбайг хатуу хучилттай болгох



**Тайлан:** Ахуйн гаралтай хог хаягдлын түр цэгийг салхины ноёлох чиглэлийн дор байгуулж, хог хаягдлын ангилан ялгаж, тогтмол хугацаанд зайлуулах, хогийн цэгийг халдваргүйжүүлж байна.


11:43
◂ Messages

НХМаягт Т-1

НЭХЭМЖЛЭХ № . . . .

Нэхэмжлэгч:
Байгууллагын нэр:
Хаяг:
Утас, факс: 80786616, 72006616
Э-шуудан:
Банкны нэр:
Банкны дансны дугаар:

Төлөгч:
Байгууллагын нэр: Цагаан ямаат Кашемир ХХК
Хаяг:
Гэрээний №
Нэхэмжилсэн огноо:
Төлбөр хийх хугацаа:

| № | Гүйлгээний утга | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|
| 1 | [illegible] | [illegible] | | 2,000,000 |
| | | | | |
| | | | Дүн | |
| | | | НӨАТ | |
| | | | Нийт дүн | 2,000,000 |

Мөнгөний дүн ........ сая төгрөг ........ болно.

(Тамга)
Дарга ........ /........./
Хүлээн авсан ........ /........./
Нягтлан бодогч ........ /........./





**Хүснэгт 2. Байгаль хамгаалах төлөвлөгөө, тайлан**

| Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, өртөгч | Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Тоо хэмжээ (5 жилээр) | Нэгж зардал (мян.төг) | Нийт зардал (.төг) | Хэрэгжүүлэгч | Хамтран хэрэгжүүлэгч | Биелэлтийн шалгуур | Баримтлах хууль журам, стандарт, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Ажилчдын эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ** | | | | | | | | | |
| Аюулгүй ажиллагаа | Ажилчдыг зориулалтын хувцас, бээлий, малгайгаар хангах, хангахдаа MNS 6654:2017 стандартыг баримтлах | Жилд 1 удаа | 22 ажилтан | 120.0 | 13,200,000 | “Цагаан ямаат кашемир” ХХК | Мэргэжлийн байгууллага | | MNS 6654:2017 |
| Ажилчдын эрүүл мэндийг хамгаалах | Бүх ажиллагсдыг мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон хугацаат эрүүл мэндийн үзлэгт хамруулах | Жилд 1 удаа | 22 ажилтан | 20.0 | 2,200,000 | “Цагаан ямаат кашемир” ХХК | Мэргэжлийн байгууллага | | - |
